



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2020.07.31 № 725
танай -ны № -т

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭ
СҮМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
“АРДЧИЛСАН НАМ”-ЫН НАМЫН ХОРООНД

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд оролцож Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл /бие даан нэр дэвшигч/ нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаарддагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Ардчилсан намын Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Ардчилсан намын мөрийн хөтөлбөр /.....хуудас-/ийг хавсаргав.

Хувийг Говь-Алтай аймгийн Эрдэнэ сумын Сонгуулийн хороонд

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТУВШИНБАЯР

07021541